

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2023 – 05 САР I ДУГААР 54

## ГАРЧИГ

2–4	Бодлогын нийтлэл
5–6	Зохицуулалтын мэдээ
7–8	Байр суурь
9	Ногоон үнэт
10–11	Финтек ба регтек
12–17	Судлаачийн индэр
18–19	Компанийн засаглалын чиг хандлага
20–21	Даатгагчийн баталгаа гэж юу вэ?
22–23	Олон улсын зах зээлийн мэдээ
24	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭЖ ЭХЭЛЛЭЭ



Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зохицуулалтын талаар Банк бус санхүүгийн байгууллагын газрын Мөнгөн зээлийн зохицуулалтын албаны референт М.Янжинлхамтай ярилцлаа.

**Ярилцлагаа банк бус санхүүгийн байгууллагуудын эрхэлж буй валютын арилжааг төрөөс анх хэрхэн зохицуулж эхэлсэн талаар яриагаар эхлүүлье.**

Санхүүгийн зохицуулах хорооноос хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан мэдээ ирүүлэх журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувийн дугаар олгох журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-уудыг баталснаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээд нь харьяалах бүртгэх байгууллагуудад хандан бүртгүүлэх боломжтой болсон.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжүүдэд хялбар, түргэн шуурхай үзүүлэх үүднээс бүртгэлийг Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн цахим



системээр хүлээн авч, хянах боломжийг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх байгууллагын хувьд хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэх боломжтой юм.

Үргэлжлэл 7-р нүүрт



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### ХЭЭЛ ХАХУУЛЬ

Хахууль санал болгож байгаа этгээдийн зүгээс хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд хууль бус үйлдэл хийхийг ятгаж мөнгө, бараа, үйлчилгээг санал болгосон үйлдэл.



### BRIBERY

The act of offering someone money, goods or services in order to persuade him or her to perform an action, often illegal, in the interests of the person offering the bribe.

*Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*



## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООН ДАХЬ БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Нэгдсэн үндэстний байгууллагын ерөнхий ассамблейн 70 дугаар чуулган 2015 онд болж, тогтвортой хөгжлийн зорилтын 17 зорилгыг баталж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжүүлж эхэлсэн. “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхий нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг билээ. Үүнээс үүдэн байгальд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, энэ чиглэлийн үйл ажиллагааг бодлогоор дэмжих ажиллагаа эхэлсэн.

Санхүүгийн зохицуулах хороо Азийн хөгжлийн банкт хамтран хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх)-ны салбарт ТА-6883 РЕГ “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө зүүн азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төслийг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Уг төслөөр ХЗХ-ны жендерийн мэдрэмжтэй ногоон санхүүгийн өнөөгийн байдал, ХЗХ-ны гишүүн эмэгтэй удирдлагатай бичил, жижиг дунд үйлдвэрлэл (БЖДҮ) эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээг тодорхойлох, ногоон төслүүд, тэр дундаа ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд ХЗХ-нд тулгарч буй саад бэрхшээл, боломжит хөшүүргийг үнэлж, тодорхойлох судалгааг төслийн

зөвлөх Т.Очирхүү гадаад зөвлөхийн дэмжлэгтэйгээр хийсэн. Судалгааг ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтан болон БЖДҮ эрхлэгч гишүүдээс гэсэн 2 эх сурвалжаас авсан байна.

Банкны салбараас эхлүүлсэн Тогтвортой Санхүүжилт (ТоС), байгальд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь сүүлийн жилүүдэд бусад санхүүгийн байгууллагаар хүрээгээ тэлэн үргэлжилж байгаа бөгөөд үүнтэй зэрэгцэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”, “Монгол Улсын ногоон таксономи”, “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-г баталсан. Зохицуулагч байгууллагууд байгальд ээлтэй ногоон санхүүжилт, хүйсээр ангилсан мэдээ, тайланг бэлтгэн гаргах боломжийг бүрдүүлсээр байна. Байгальд ээлтэй ногоон санхүүжилт нь зөвхөн хөрөнгө их хэмжээгээр шаардагдах эдийн засгийн салбарт бус хэрэглээний салбарт, Улаанбаатар хот, орон нутагт ялгалгүй хэрэгжиж буй жишээ олноор бий болж байгаа бөгөөд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо нь байгальд ээлтэй ногоон зээл, хүйсээр ангилсан тоон мэдээлэл гаргуулж эхлээд багагүй хугацаа өнгөрч байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос бэлтгэн гаргадаг ХЗХ-ны 2022 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн

нэгтгэлийн танилцуулгаар 70 гаруй мянган гишүүдтэй салбарын хувьд судалгааг нэгтгэн тоймловог дараах байдалтай байна. Үүнд:

### ХЗХ–НЫ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд нийт 112 ХЗХ–ны эрх бүхий албан тушаалтан хамрагдсан. Үүнээс 55 нь УБ хот, 57 нь орон нутгийн ХЗХ–ны эрх бүхий албан тушаалтан ба нийт ХЗХ–ны үйл ажиллагаа эрхэлсэн дундаж хугацаа нь 11.4 жил, 100–500 хүртэл гишүүнтэй ХЗХ судалгаанд илүүтэй хамрагдсан ба ХЗХ–ны дийлэнх нь эмэгтэй удирдлага (нийт хоршоодын 67%)–тай бол гишүүн хуулийн этгээдийн дийлэнх нь эрэгтэй удирдлагатай байна. Зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагаа эрхлэх хэлбэрийн хувьд ХЗХ–ны тэргүүлэгчдийн зөвлөлд эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага бол хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, ажилтнуудын хувьд эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс их бөгөөд нэгтгэн дүгнэвэл Монгол Улсын ХЗХ–ны салбарын нийт гишүүд болон үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтцэд эмэгтэйчүүдийн хувь оролцоо өндөр байна.

Ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, ангилал, тавигдах шалгуур үзүүлэлт, нөхцөл, хэмжих үзүүлэлтийг тодорхойлох, ХЗХ–нд сурталчлах, мэдээлэл хүргэх, сургах шаардлагатай бөгөөд үр дүнг хэмжих, үнэлэх, дүгнэх бодлого, журам, заавар, арга зүй дутагдалтай байгаа нь ХЗХ–ны удирдлагын 71 хувь байгальд ээлтэй ногоон санхүүжилтийн талаар мэдлэг, мэдээлэлтэй гэж хариулсан боловч 24 ХЗХ 2022 онд 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос харагдаж байна. Мөн ногоон төслүүдийг тодорхойлох, тэдгээр төслүүдэд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад тавигдах шалгуур байхгүй, бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад ногоон зээлийн ашиг тусын талаар мэдээлэл бага гэсэн хариултыг ихээр ирүүлсэн.

Байгальд ээлтэй ногоон санхүүжилтийг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээл/сорилтуудыг хөнгөлөлттэй санхүүжилт байхгүй, мэдээлэл дутмаг, байхгүй, цаг агаар, улирлын таатай бус байдал, ажиллах хүч дутмаг зэрэг дарааллаар ХЗХ–оос хамгийн их хариулт ирүүлснийг багцлан дүгнэвэл ХЗХ нь чөлөөт мөнгөн хөрөнгийн дутагдалтай, эх үүсвэр хангалтгүй ба санхүүжилт авах мэдээллийн суваг бага, улирлын чанартай хөдөө аж ахуйн салбарт ажилладаг байна. Саад бэрхшээл/сорилтуудыг даван туулах зорилгоор хадгаламж татан төвлөрүүлсэн, хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх ажил өрнүүлсэн, төсөлд хамрагдахаар ажиллаж байгаа, мэдээлэл олж авах ажил гүйцэтгэсэн дийлэнх ХЗХ–дод

эх үүсвэрийн өртөг бага, урт хугацаат санхүүжилт зайлшгүй шаардлагатай байна.

### ХЗХ–НЫ ГИШҮҮН БЖДҮ ЭРХЛЭГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нийт 82 ХЗХ–ны эрх бүхий албан тушаалтан нь өөрийн ХЗХ–ны гишүүн нийт 1288 (үүнээс орон нутгийн 942) БЖДҮ эрхлэгчдийн мэдээллийг ирүүлсэн ба хүйсээр ангилбал 691 нь эмэгтэй, 597 нь эрэгтэй байна. Гэр бүлтэй, 3–5 өрхийн гишүүд бүхий, 36–45 насны, дээд боловсролтой, 8–аас дээш жил аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй, тусгай зөвшөөрөл үл шаардагдах, зохицуулалт бага, албан бус секторт ажилладаг, эрхэлж буй үйл ажиллагаагаа жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчээр бүртгүүлээгүй, эд хөрөнгөө дангаар өмчилдөг, 2–5 удаа зээл авч байсан, орон нутгийн ХЗХ–ны гишүүн эмэгтэйчүүд судалгаанд илүүтэй хамрагдсан. ХЗХ–ны ихэнх гишүүд нь 5 хүртэлх сая төгрөгийн зээлийг 6 сараас 1 жилийн хугацаатай, төгрөгийн 18–аас дээш хувийн жилийн хүүгээр, хөнгөлөлттэй нөхцөлгүй, эргэлтийн хөрөнгийн зориулалттай зээлийг хөдлөх, үл хөдлөх хосолсон барьцаатайгаар гол төлөв зээл авсан ба санхүүгийн бус дэмжлэгийг өмнө нь авч байгаагүй байна. Хариултаудыг багцалбал ХЗХ–ны гишүүдийн дийлэнх нь төрөөс олгодог бага хүүтэй, урт хугацаат ЖДҮ–ийн дэмжлэгийг бага хүртсэн, орон нутгийн, хөрөнгө, хөдөлмөрөөр хоршсон “туршлагатай зээлдэгч” эмэгтэйчүүд байна.

ХЗХ–ны гишүүдийн дийлэнх нь хүйсийн ялгаварлалтай холбоотойгоор хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгаагүй гэж хариулт ирүүлсэн нь Монгол Улсын хувьд жендерийн ялгаварлал багатай буюу хүнийг нас, хүйс, шашин шүтлэг, гарал үүслээр нь ялгаварлан гадуурхдаггүй сайн жишгийг ХЗХ–ны салбарт үзүүлсэн байна. Энэ нь ХЗХ–ны салбарт эмэгтэйчүүд илүүтэй ажилладагтай холбоотой байж болох талтай.

### ДҮГНЭЛТ

ХЗХ–ны салбарт хүйсийн ялгаварлал бага, харин байгальд ээлтэй ногоон санхүүжилтийн талаарх ерөнхий болон нарийвчилсан мэдээлэл хангалтгүй тул ХЗХ–ны эрх бүхий албан тушаалтан, гишүүн БЖДҮ эрхлэгчдэд ногоон санхүүжилтийн талаар танилцуулга, ухуулга, сурталчилгааг хүргэх ажлыг эрчимтэй хийж, мэдлэгийг тэлэн, чадавхыг сайжруулах шаардлагатай байна. Энэ ажлыг гүйцэтгэсэнээр ХЗХ–ны салбарын ногоон санхүүжилтийн хөгжил хурдсах ба материал түүхий эдийн хэмнэлт бий болж, тойрог эдийн засгийн загвар нэвтрэн, хог

хаягдлын хэмжээ буурах боломж бүрдэх бөгөөд Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-т дурдсаны дагуу банкнаас бусад санхүүгийн байгууллагын олгосон нийт зээлийн багцын 5-аас доошгүй хувийг 2030 он хүртэл ногоон зээлээр бүрдүүлэх зорилтыг хангах, Парисын хэлэлцээрт нэгдсэн зорилтдоо хүрэх боломж бүрдэх юм. Харин ХЗХ-ны харилцагч, хэрэглэгчдийн хувьд сэтгэл ханамж нэмэгдэн байгальд ээлтэй хэрэглээ, дадал бий болох үр дүнтэй.

### САНАЛ ЗӨВЛӨМЖ

Үндэсний хэмжээнд жендерийн мэдрэмж бүхий ногоон санхүүжилттэй холбоотой нэгдсэн өгөгдөл мэдээлэл хангалтгүй, байгууллага бүр мэдээллийг бие даан хөтөлж байгаатай холбогдуулан төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, статистикийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх шаардлагатай байна. Дунд, урт хугацаанд улсын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендерийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлт бий болох боломж бүрдэнэ.

Жендерийн мэдрэмжтэй ногоон санхүүжилтэд тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлт, үр дүнг үнэлэх, хэмжих, хянах, тайлагнах журам, заавар, гарын авлага, арга аргачлалыг боловсруулах ХЗХ-дын үйл ажиллагаанд үе шаттайгаар нэвтрүүлэх; Гадаад орчны өөрчлөлттэй уялдуулан жендерийн мэдрэмжтэй байгальд ээлтэй ногоон санхүүжилтийн талаарх мэдээлэл, мэдлэг түгээх ажлыг өргөн хүрээтэй хийж сурталчлан таниулах, ХЗХ-дод ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулах; Зохицуулагч байгууллагаас зохион байгуулдаг сургалт, шалгалтад жендерийн мэдрэмжтэй, байгальд ээлтэй ногоон санхүүжилтийн талаарх мэдээллийг оруулах; Санхүүгийн эх үүсвэр дутагдалтай салбарын хувьд ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг гадаад, дотоод эх үүсвэрээс бүрдүүлэх, дамжуулан олгох төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бололцоог бүрдүүлж, татаас, татварын урамшууллыг нэвтрүүлэх ажлуудыг хийх шаардлагатай.

ХЗХ-ны хувьд байгууллагын эрхэм зорилго, зорилт, бодлого, стратеги, засаглалд байгальд ээлтэй байх, хүйсийн тэгш байдлыг хангах талаар тусгах; Байгальд ээлтэй түүхий эд материалыг бизнесийн үйл ажиллагаанд түлхүү ашиглах, үйлдвэрлэл, хэрэглээнээс үүдэлтэй хог хаягдлын хэмжээг бууруулах, түүнийг


дахин ашиглах загвар үйлдвэрлэл, хэрэглээг бүрдүүлэх; Бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийн сүлжээний бүрдэлд анхаарал хандуулах, тойрог эдийн засгийн зарчмаар ажиллан, зээлийн эрсдэлийг бууруулах, эрсдэлээс сэргийлэх; Байгальд ээлтэй, хог хаягдлын хэмжээг бууруулсан, шинэ технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх; Байгууллага дотор байгальд ээлтэй зан үйлийг дэмжин сурталчлан дэлгэрүүлэх, манлайлагчийг тодруулан урамшуулах, алдаршуулах; Хүйсээр ялгаварлан гадуурхах, байгаль орчныг сүйтгэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих; Олон улсын гэрээ конвенцоор хориглосон, байгаль орчинд хор хөнөөлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх талаар үйл ажиллагааны бодлого, журамд тусгах талаар анхаарах шаардлагатай гэжээ.

Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн цаашид Санхүүгийн зохицуулах хорооноос байгальд ээлтэй ногоон санхүүжилтийг бодлогоор дэмжих, жендерийн мэдрэмжтэй мэдээллийн сан байгуулах зэрэг ажлыг үйл ажиллагаандаа тусгаж ажиллана.



## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРЛОЦООГ ӨСГӨХ ХӨТӨЛБӨРИЙГ БАТАЛЛАА



Монгол Улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хөгжилд чухал нөлөө үзүүлж буй үндэсний ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөрийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин нар баталж, гарын үсэг зурлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр “УИХ, Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй “Зээлийн хүүг бууруулах стратеги”, банкны салбарын реформ, төрийн өмчит компанийн хувьчлал зэрэг томоохон шинэчлэлийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, дотоодын аж ахуйн нэгжүүдийг шинэ бүтээгдэхүүн гаргахад тухай бүрд нь дэмжлэг үзүүлж ирсний үр дүнд сүүлийн хоёр жилийн хугацаанд 60 санхүүгийн шинэ бүтээгдэхүүн гарч, өчигдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 8.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар өссөн байна. Түүнчлэн энэ хугацаанд 5 компани IPO хийж, нийт 340 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлсэн бол 1 компани 20.0 тэрбум төгрөгийн нээлттэй бонд гаргаж, биржийн бус зах зээл дээр 76 компани 100 гаруй шинэ бүтээгдэхүүн гаргаж, нийт 1.1 их наяд төгрөгийг татан төвлөрүүлээд байна. Харин өнөөдрийн баталсан хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж

ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд IPO хийх, компанийн бонд гаргахад тавих нөхцөл, шаардлага, цаг хугацаа, өртгийг бууруулж, үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах хүрээнд IPO хийхэд хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй. Түүнчлэн нээлттэй, хаалттай хүрээнд бонд гаргахад барьцаа, батлан даалт мөн заавал андеррайтертай гэрээ байгуулах зэргийг шаардахгүй байх зэрэг нэлээдгүй арга хэмжээг хэрэгжүүлнэ. Иймд Монгол Улсын шилдэг аж ахуйн нэгжүүд та бүхнийг IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох, компанийн бонд гаргаж хямд санхүүжилт татах замаар хөрөнгийн зах зээлд идэвхтэй оролцож, эдийн засаг, санхүүгийн салбарын цаашдын хөгжилд хувь нэмрээ оруулахыг уриалж байна” гэдгийг онцолсон юм.

ТОП-100 аж ахуйн нэгжүүд нь IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох, компанийн бонд гаргаж санхүүжилт татах замаар хөрөнгийн зах зээлд оролцсоноор бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, ашиг, орлогоо өсгөх, урт хугацааны хямд санхүүжилтийн эх үүсвэр татах, компанийнхаа засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой юм. Мөн энэ үеэр анх удаа хувийн хэвшлээс ТОП-100 аж ахуйн нэгжийг тодруулж өргөмжлөлийг гардуулсан юм. Тодруулбал, эдгээр аж ахуйн нэгжийг Санхүүгийн зохицуулах хороо, МҮХАҮТ, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо хамтран эрэмбэлэхдээ төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийг оролцуулаагүй бөгөөд 51 ба түүнээс дээш хувь нь хувийн өмчит аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлд үндэслэн гаргав.

### УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЖУРМЫН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦЛЭЭ



УИХ-аас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан нэр бүхий дөрвөн журмын төслүүдийн хэлэлцүүлэг боллоо. Тодруулбал, “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа төлбөр, тооцоо хийх ерөнхий журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам”, “Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам”-ын төслүүд тус бүрийг хэлэлцэв.

Хэлэлцүүлэгт үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд, үнэт цаасны компаниуд, уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцох сонирхол бүхий этгээдүүдийн төлөөлөл оролцлоо.



### БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫНХАН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНДЭЭ МОД ТАРИЛАА

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, Нийслэлийн байгаль орчны газар хамтран бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан Минж үржүүлэх, нутагшуулах төвд байрлах нэрэмжит цэцэрлэгт хүрээлэндээ 2023 оны 5 дугаар сарын 13-ны амралтын өдөр мод тариалаа. Эх байгалиа хайрлан хамгаалж, амьдрах орчноо эрүүл, цэнгэг болгох зорилгоор зохион байгуулсан энэхүү өдөрлөгт Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын хамт олон болон Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны гишүүн 19 банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөл оролцож нийт 640 гаруй мод тариалаа.

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо нь нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан зарласан “Нэг тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж салбарынхантайгаа нэгдэж 2.7 сая мод тарих амлалт өгсөн. Энэ хүрээнд Минж үржүүлэх, нутагшуулах төвд банк бус санхүүгийн байгууллагуудын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг байгуулж одоогоор найман төрлийн 2,240 гаруй мод тариад байгаа ажээ.

### ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГИЙН ШИНЭЭР ТОМИЛОГДОХ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧТЭЙ УУЛЗЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан ОУВС-гаас Монгол дахь суурин төлөөлөгчөөр шинээр томилогдон ирээд буй Тигран Покхосеныг хүлээн авч уулзлаа. Энэ үеэр Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн салбарыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангахад хэрхэн анхаарч ажиллаж байгаа мөн ОУВС-тай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн явц, үр дүнгийн талаар санал солилцлоо. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан уулзалтын эхэнд “Монгол Улсын санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах тэр дундаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын гол арга хэмжээ, түүний үр дүнгүүд ОУВС-ийн хамтын ажиллагаатай шууд холбоотой хэмээн онцоллоо. Мөн тэрбээр энэ онд болон цаашид урт хугацаандаа хамтын ажиллагаагаа улам нэгтгэх, Монгол Улсын санхүүгийн зах зээлийг хөгжүүлж, тогтвортой байдлыг бэхжүүлэхийн төлөө хамтран ажиллаж, зөвлөгч түнш нь байхыг хүслээ.

Ноён Тигран Покхосен ч Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, тулгамдаж буй асуудлуудыг нь шийдвэрлэхэд хамтран ажиллахад хэзээд таатай байна гэдгээ илэрхийлсэн юм.

## БАЙР СУУРЬ

### МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭЖ ЭХЭЛЛЭЭ

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зохицуулалтын талаар Банк бус санхүүгийн байгууллагын газрын Мөнгөн зээлийн зохицуулалтын албаны референт М.Янжинлхамтай ярилцлаа.

Эхлэл нь 1-р нүүрт



#### **Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжүүд ямар шаардлагыг хангасан байх ёстой вэ?**

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавих шаардлагыг тодорхой зохицуулж өгсөн. Тухайлбал, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 10,000,000 (арван сая) төгрөгөөс багагүй байх, мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалтад хамрагдсан байх, мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зориулсан банкны харилцах данстай байх, татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх, татварын нэгдсэн системд холбогдсон кассын машин, хэвлэх төхөөрөмжтэй байх, мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбогдсон шаардлагатай мэдээлэл авах боломжийг хангасан цахим бүртгэлтэй байх, гүйцэтгэх удирдлага, менежер нь гэмт хэрэгт хариуцлага хүлээж байгаагүй байх гэх мэт.

Хуульд заасан шаардлагаас гадна мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн оруулж буй мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдэж байгааг нотлох шаардлагатай. Ингэснээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, далд эдийн засгийг халах, хууль бус мөнгөн хөрөнгө санхүүгийн зах зээлд орох эрсдэлийг бууруулах юм.

#### **Дээрх шаардлагыг хангасан этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тухай хүсэлтийг хаана гаргаж, яаж бүртгүүлэх вэ?**

Барьцаалан зээлдүүлэх журмаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь орон нутагт 100,000,000 (зуун сая) төгрөг, түүнээс дээш, нийслэлд 300,000,000 (гурван зуун сая) төгрөг, түүнээс дээш бол Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтээ ирүүлнэ. Харин хуульд заасанчлан мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэний хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс үл шалтгаалан тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад өргөдөл гаргаж бүртгүүлнэ. Бүртгүүлэх хүсэлтээ дээр дурдсанчлан Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн системээр дамжуулан өргөдөл гаргах боломжтой юм.

#### **Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжийн хүсэлтийг ямар хугацаанд бүртгэж, хянах вэ? Бүртгэхээс татгалзах тохиолдол байх уу?**

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үйл ажиллагаа явуулж байсан барьцаалан зээлдүүлэх газар цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах

бол хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн дотор харьяа байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. Өргөдөл гаргагчийн баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан тохиолдолд баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор хянаж, шаардлага хангасан өргөдөл гаргагчийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоно.

Өргөдөл гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу бол бүртгэх байгууллага энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэх бөгөөд өргөдөл гаргагч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг хангаж ирүүлнэ. Энэ хугацаанд дутуу эсхүл баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд бүртгэх байгууллага тухайн өргөдөл гаргагчийг бүртгэхээс татгалзана. Өргөдөл гаргагч дээрх баримт бичгүүдийг бүрэн ирүүлээгүй, ирүүлсэн баримт бичиг хуурамч болох нь тогтоогдсон бол бүртгэх байгууллага өргөдөл гаргагчийг бүртгэхээс татгалзаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

***Та түрүүн дурдсан мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага, менежер нь сургалтад хамрагдах шаардлагатай гэсэн. Хэрхэн сургалтад хамрагдах вэ?***

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд зааснаар сургалт явуулах байгууллагад тавигдах шаардлага, сургалтын хөтөлбөр, арга хэлбэр болон сургалт явуулахтай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална гэж заасны дагуу “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”-ыг баталсан. Санхүүгийн зохицуулах хорооноос сургалтыг 1 жилийн хугацаанд үнэ төлбөргүй зохион байгуулахаар заасны дагуу Санхүүгийн боловсролын НУВ сургалтын төвтэй хамтран цахимаар зохион байгуулж байна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь тус сургалтад хамрагдахдаа ажлын өдрүүдэд ажлын цагаар бүртгүүлж нэвтрэх нэр, нууц үгээ авах боломжтой бөгөөд хичээлийн хөтөлбөрийг 72 цагийн дотор (3 хоног) судалж, шалгалтаа өгөн гэрчилгээгээ татан авч бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтад хавсаргана. Өнөөдрийн байдлаар тус сургалтад 415 иргэн, хуулийн этгээд хамрагдан гэрчилгээ авсан байна.

***Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоохоор заасан байсан. Энэ талаар мэдээлэл өгнө үү?***

Хуульд заасан төлөөллүүдийг оролцуулсан Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийг 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 137 дугаар тогтоолоор баталсан.

Зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох ажлын хүрээнд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэж байгаа байгууллагуудын үйл ажиллагааны бодит зардлыг тодорхойлох, зээлийн чанар, зээлийн багц, барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа, барьцааны зүйлийг худалдан борлуулах процесс, мөнгөний бодлогын хүүтэй хэрхэн уялдуулах талаар судалгаанууд хийгдэж байна. Судалгааны үр дүнг Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлд танилцуулсны үндсэн дээр зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоохоор ажиллаж байна. Тус зөвлөл нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хэрэглэх зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загварыг батлах, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг батлах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

***Бидэнд тодорхой мэдээлэл өгсөн танд баярлалаа***

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## НОГООН ҮНЭТ ЦААСЖУУЛАЛТ



Ногоон үнэт цаасжуулалт нь ногоон зээлийг багцлан хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчдад санал болгодог үнэт цаасны төрөл юм. Уг төрлийн үнэт цаасжуулалт нь банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад хөрөнгө татах боломжийг нэмэгдүүлдэг бол хөрөнгө оруулагчдад хөрвөх чадварыг бий болгодог.

### Ногоон үнэт цаасжуулалтын ногоон төслийг санхүүжүүлэхэд гүйцэтгэдэг үүргүүд:

1. Тогтвортой төслүүдийг санхүүжүүлэх боломж сайжирдаг. Ногоон зээл нь хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татахад жижиг байдаг бол үнэт цаасжуулалт нь эдгээр жижиг хөрөнгүүдийг нэгтгэснээр боломжийг бий болгодог.
2. Тогтвортой зээл бий болгох чадвар нэмэгддэгээрээ ногоон зээлийн бизнесээ тэлэх хөшүүрэг болдог.
3. Ногоон төслийн хөрөнгө оруулагчид нэмэгддэг.
4. Төвлөрлийн эрсдэлийг бууруулдаг.
5. Хөрөнгө оруулагчдад төлөх өглөгийн хугацааг удирдахад тусалдаг.

Ногоон бондтой харьцуулахад ногоон үнэт цаасжуулалтын стандарт болон зарчмууд хөгжлийн эхэн үедээ байгаа бөгөөд хамгаалалттай ногоон бонд болон ногоон үнэт цаасжуулалт нь нэг ангилал дор багтдаг.



Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооноос “Ногоон бондын зарчим”-ын хавсралтад ногоон үнэт цаасжуулалтын зөвлөмжийг 2022 оны 6 дугаар сард шинээр тусгасан. Ногоон үнэт цаасжуулалтын бүлэгт баталгаатай бонд, үнэт цаасжуулалт, хөрөнгөөр баталгаажсан арилжааны үнэт цаас, хамгаалалттай өрийн бичиг зэрэг орно. Түүнчлэн зарчмуудад 300 гаруй гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг багтаасан.

Европын банкнуудын зохицуулагчаас 2022 оны 3 дугаар сард тогтвортой үнэт цаасжуулалтын зарчим, түүний ил тод байдлын шаардлагыг боловсруулах тайланг олон нийтэд мэдээлсэн. Ингэхдээ Европын холбооны ногоон бондын стандартын зохицуулалтад ногоон үнэт цаасжуулалтыг нэмж тусгах, тус үнэт цаасанд тавигдах шалгуурыг гаргах, байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдлын стандартыг оруулах юм.



Ногоон үнэт цаасжуулалтын зах зээл нь Европын холбооны ESG бонд гаргалтын 2 хувь, нийт үнэт цаасжуулалтын 6 хувийг эзэлж байна. уг үзүүлэлт нь Хятад болон АНУ-тай харьцуулахад бага тоо хэдий ч 2022 оны 12 дугаар сард Европын санхүүгийн зах зээлийн холбооноос ногоон үнэт цаасжуулалтыг ногоон санхүүжилтэд хувь нэмэр оруулах томоохон боломж үүссэн гэж харж байгаа ба 2030 онд 300 их наяд еврог давсан санхүүжилт татах потенциал байгааг онцолсон.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### БЛОКЧЭЙН БА КРИПТОВАЛЮТ БОЛОН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэнд блокчэйн ба криптовалют болон түүний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ.

Блокчэйн нь төвлөрсөн бус өгөгдлийн сангийн технологийн шинэ шийдэл бөгөөд энэхүү шинэчлэлт нь хуучин технологийг орчин үеийн шийдэлтэй хослуулан хөгжиж байна. Блокчэйн нь бие даасан хэрэглэгчдийн мэдээллийн санг хадгалж, хуваалцаж мөн удирдаж ажиллах төвлөрсөн бус өгөгдлийн сан гэж ойлгож болно. Тархсан P2P сүлжээ гэдэг нь сүлжээнд оролцогч талууд нь газарзүйн хувьд тархсан байдаг ба байршлаас үл хамааран ямар нэг серверээр дамжилгүйгээр өөр хоорондоо шууд холбогддог.


DLT технологи нь мэдээллийг тархсан P2P сүлжээний оролцогч нар дээр хадгалагддаг технологи бөгөөд уламжлалт өгөгдлийн сангийн системээс ялгарах гол ялгаа нь төвлөрсөн өгөгдлийн сан болон төвлөрсөн удирдлагын функцгүй юм.

Блокчэйн нь DLT технологийн гол төлөөлөгч бөгөөд мэдээллийн гинжин хэлхээ юм. Блокчэйнд тогтсон хэмжээтэй блок үүсгэж, үүн дотроо мэдээллийг хадгалах ба эхний блок дүүрэхэд дараагийн шинэ блок үүсгэдэг. Эдгээр блок нь хэйш функцээр кодлогдсон байх ба блокийг цаг хугацааны дагуу жагсааж, блок тус бүр яг өөрийн өмнөх блокийн мэдээллийг өөр дотроо хадгалах байдлаар гинжин бүтцийг үүсгэнэ. Блокчэйн технологийн хамгийн чухал, онцлох давуу тал нь төвлөрсөн бус тархсан бүтэцтэй бөгөөд сүлжээнд байгаа компьютер бүр блокчэйний халдашгүй чанарыг үргэлж баталгаажуулж байдаг ба хэн нэгэн, эсвэл аль нэг байгууллага болон хувь хүн үүн доторх өгөгдөл түүний бүрэн бүтэн байдлыг удирдах боломжгүй байдгаараа давуу талтай юм.


Криптовалют нь интернэт орчинд аливаа төрийн байгууллага болон банк гэх мэт төвлөрсөн санхүүгийн байгууллагын удирдлагагүйгээр арилжааны хэрэгсэл болох зориулалттай дижитал валют. Криптовалют ашиглан арилжаа хийгдэхэд арилжаанд оролцож буй талууд найдвартай, баталгаатай болохыг төвлөрсөн бус байдлаар баталгаажуулдаг онцлогтой бөгөөд ингэснээр банк гэх мэт төвлөрсөн санхүүгийн болон арилжааны байгууллагын оролцоогүйгээр явагддаг.

#### Блокчэйн ба криптовалют өнөөгийн нөхцөл, байдал

Дэлхий даяар криптовалютын салбарт 30.0 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн 2021 оны огцом өсөлтийн дараа криптовалют болон блокчэйн дэх нийт хөрөнгө оруулалт 2022 онд 23.1 тэрбум ам.доллар болж буурсан ч хөрөнгө оруулалтын түвшин 2021 оноос өмнөх бүх жилүүдтэй харьцуулахад өндөр хэвээр байна. 2022 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын дийлэнх нь тухайн оны эхний хагас жилд гарсан бөгөөд үүнд Японд төвтэй Coincheck компани 1.1 тэрбум ам.долларын SPAC нэгдэл хийсэн бол Германд төвтэй Trade Republic компани 1.1 тэрбум ам.долларын венчур капиталын хөрөнгө оруулалт татсан байна. 2022 оны сүүлийн хагас жилийн хамгийн томоохон хэлцлүүд нь Сингапурт төвтэй крипто арилжааны платформ болох Amber 300.0 сая ам.долларын венчур капиталын, Кайманы аралд төвтэй этериум хөгжүүлэлтийн Matter Labs фирм 200.0 сая ам.долларын, АНУ-д төвтэй төвлөрсөн бус криптовалютын бирж болох Uniswap 165.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт тус тус татсан зэрэг нь хамгийн томоохон үзүүлэлтүүд болжээ.



Зураг. Дэлхийн блокчэйн ба криптовалютын 2022 оны хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG

Зохицуулагчид хөрөнгө оруулагчид болон хэрэглэгчдийг эрсдэлээс хамгаалахад анхаарал хандуулж байна.

2022 онд улс орнууд криптовалютын зохицуулалтад илүүтэйгээр анхаарал хандуулсан жил болсон бөгөөд үүнтэй холбоотой дүрэм, журам, зааврууд ихээр гаргасан ба тэдгээрийн ихэнх нь хэрэглэгчид болон жижиг хөрөнгө оруулагчдыг хамгаалахад чиглэгдсэн байжээ. Тус онд крипто зах зээлд тулгарч буй сорилтуудыг даван туулсан Сингапур зэрэг улс орнууд криптовалютын зохицуулалтыг сайжруулснаар өөрийн улсыг аюулгүй крипто-төв гэж тодорхойлж эхлээд байна.

### 2023 оны блокчэйн болон криптовалют салбарын чиг, хандлага, хөгжүүлэлт

- ◆ DeFi болон илүү өргөн хүрээний шийдэл болох хил дамнасан төлбөр тооцоо, хөрөнгийн токенжуулалт зэрэг блокчэйд суурилсан компаниудад чиглэсэн хөрөнгө оруулалтууд түлхүү хийгдэж байна.
- ◆ Зохицуулагч байгууллагууд криптовалютын компаниудын болон тухайн чиглэлийн харилцааны эрх зүйн орчныг сайжруулах, шинэ зохицуулалт нэвтрүүлэх чиглэлээр анхаарал хандуулж байна.
- ◆ Хөрөнгө оруулагчид шинэ хөрөнгө оруулалт хийхээс илүүтэйгээр өөрийн криптовалютын аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагыг сайжруулахад ихээхэн хугацаа зарцуулж байна.
- ◆ Япон, Хонконг, Сингапур зэрэг улсууд хөрөнгө оруулагчид болон гарааны компаниудын криптовалютын арилжааны зохицуулалтыг сайжруулахыг зорьж байна.
- ◆ Улс орнууд стэйблкойныг хөгжүүлэх, туршихад илүү анхаарал хандуулсаар байна.

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

/ХУРААНГУЙЛСАН/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

#### ХУРААНГУЙ

Мэргэжлийн хөрөнгө оруулагчид буюу тэтгэврийн сан, даатгалын компани, хөрөнгө оруулалтын сан зэрэг нь дэлхийн эдийн засагт томоохон тоглогчид бөгөөд тэдгээрийн олон улсын зах зээлд эзлэх хувь хэмжээ тасралтгүй нэмэгдсээр байна. Монгол Улсад төдийгүй дэлхий даяар хөрөнгийн зах зээл эрчимтэй хөгжиж буй өнөө цагт хөрөнгийн зах зээлийг хэлбэлзэл багатай, тогтвортой хөгжүүлэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо нэн чухал. Энэхүү судалгаагаар хөрөнгийн зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдын өнөөгийн байдал, тэдгээрийн үүрэг оролцоо, тэдгээрийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэхийн давуу тал, олон улсын чиг хандлагын талаар судаллаа.

#### УДИРТГАЛ

Аливаа улсын дундаж давхарга тэлэхийн хэрээр тухайн улсын эдийн засаг тогтвортой байдаг. Дэлхийн банкны хийсэн судалгаа болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-Алсын хараа 2050-д 2020 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 27.8 хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй, нийт хүн амын 61.3 хувь нь хөдөлмөрийн насныхан ч тэдний 52.3 хувь нь л хөдөлмөр эрхэлж байна хэмээн тусгажээ. Дундаж давхаргад тэгш бус байдлыг бий болгож, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд томоохон сорилт болж байна.

Дундаж давхарга бол улс орны бүтээгдэхүүн үйлчилгээний тогтвортой хэрэглээ, өсөлтийн гол суурь, шинийг эрэлхийлэгч, эрсдэл гаргагч энтрепренер, хүмүүн ба санхүүгийн капитал хуримтлуулагч, итгэлцлийг нэмэгдүүлж, ил тод байдал, хариуцлагыг шаардах гол хүч байдаг.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн Б.Батцэцэг  
Battsetseg\_b@frc.mn

Дундаж давхаргыг тэлэхэд олон хүчин зүйлс нөлөөлдөг ч хөрөнгийн зах зээлийн оролцоо маш чухал байдаг. Харин хөрөнгийн зах зээлийг мэргэжлийн хөрөнгө оруулагчид тогтвортой хөгжүүлдэг байна.

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 90 хувийг банкны салбар эзэлдэг байсан бол сүүлийн хоёр жил хэрэгжүүлж буй зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийн хүрээнд хөрөнгийн зах зээл тэр дундаа мэргэжлийн хөрөнгө оруулагчдын орон зай тэлэн нэмэгдэх боломжтой болсон.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, даатгалын компани зэрэг нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангасан ашигтай, зөв хөрөнгө оруулалт хийхэд чухал үүрэг гүйцэтгэдэг<sup>1</sup>. Мөн зөвхөн санхүүгийн өгөөжөөс гадна, тухайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөө, нийгэмд ээлтэй байгаа эсэх, засаглалын хувьд эрүүл, тэнцвэртэй эсэх зэрэг байгаль орчин, нийгэм, засаглал /ESG/ өндөр ач холбогдолтой байгаа өнөө үед засаглалд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо тун чухал. Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулсан нээлттэй болон хаалттай компаниудын засаглал сайжирдаг гэсэн олон улсын судалгаа бий<sup>2</sup>. Ихэнх компаниудын гол хувьцаа эзэмшигч нь нэг хүн эсхүл нэг гэр бүл байдаг бөгөөд энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн тухайн компанид итгэх итгэлцэл, нээлттэй ил тод байдал, засаглалд сөргөөр нөлөөлдөг. Жижиг хөрөнгө оруулагч нар судалгаа шинжилгээ хангалтгүйгээр богино хугацаанд их ашиг олох сонирхолдоо хөтлөгдөн арилжаа хийдэг. Энэ нь хөрөнгийн зах зээл дээр савлагаа үүсгэдэг. Хувь хүмүүсийн цөөнх хэсэгт ашигтай байж болох ч энэ нь урт

хугацаандаа сөрөг нөлөө үзүүлдэг. Харин хөрөнгө оруулалтын сан зэрэг мэргэжлийн хөрөнгө оруулагчид нь судалгаа шинжилгээний үндсэн дээр мэргэжлийн хүмүүс ажилладаг тул урт хугацаанд хөрөнгө оруулж, салбарын тогтвортой байдал, нэр хүндэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хөрөнгө оруулсан компанийнхаа үйл ажиллагаа, тогтвортой байдал, засаглал, хяналтад гар бие оролцон ажилладаг.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлөөр тэргүүлэгч АНУ-ын нийт хөрөнгийн зах зээлд эргэлдэж байгаа хөрөнгийн 80 хувь нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдаар дамждаг бол дэлхийн хэмжээнд 31 хувь мэргэжлийн хөрөнгө оруулагчдаар дамждаг байна. Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээрх нийт арилжааны 85-аас илүү хувийг мэргэжлийн хөрөнгө оруулагчид эзэлж байна<sup>3</sup>.

Энэхүү судалгааны дүгнэлтээр олон улсад хүн бүр банканд данстай, төлбөр тооцооны карттай байдаг шиг хүн бүр хөрөнгийн зах зээлийн оролцогч байдаг төдийгүй тэр оролцоогоо мэргэжлийн удирдлагатай, хөрөнгө оруулалтын сангаар дамжуулж хийдэг жишиг рүү манай зах зээл илүү сайн хөгжих хэрэгтэй. Гадаадын болон дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын сангийн орлогыг татвараас чөлөөлөх зэрэг татварын бодлогоор дэмжих хэрэгтэй. Түүнчлэн олон нийтийн болон жижиг хөрөнгө оруулагч нарын мэдлэг, мэдээллийг сайжруулах, цаашлаад тус салбарыг хөгжүүлэхэд хүний нөөцийн асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай болно.

<sup>1</sup>Азийн хөгжлийн банк, 2019 он

<sup>2</sup>Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага

<sup>3</sup>Reuters. "Retail Traders Account for 10% of U.S. Stock Trading Volume—Morgan Stanley, 2021

## МОНГОЛ УЛС ДАХЬ МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд мэргэжлийн хөрөнгө оруулагч, мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа гэдгийг дараах байдлаар томъёолсон.

**Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.18.** "мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа" гэж хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгөөр энэ хуулийн 4.1.19-д заасан банк бус санхүүгийн байгууллага, андеррайтер, дилерээс бусад этгээд мэргэжлийн түвшинд үр ашигтай хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааг;

4.1.19. "мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч" гэж мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгал, андеррайтер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд зэрэг хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэж үзсэн бусад этгээдийг хэлнэ.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг 2013 онд УИХ баталснаар хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт бий болсон.

Хөрөнгө оруулалтын сан нь бусдаас мөнгөн хөрөнгө төвлөрүүлж, мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр бусдаас төвлөрүүлсэн хөрөнгөөрөө хувьцаа, бонд зэрэг санхүүгийн хэрэгсэлд үр ашигтайгаар хөрөнгө оруулах байдлаар сангийн нэгж эрх эзэмшигчдэд өгөөж хүртэх боломжийг олгодог байгууллага юм.

Олон улсын жишиг болон Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд зааснаар хөрөнгө оруулалтын сан нь хамтын болон хувийн гэсэн 2 хэлбэр, нээлттэй болон хаалттай гэсэн 2 төрөлтэй.

Зураг. Хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр, төрөл



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль

Хувийн хөрөнгө оруулалтын санд зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулдаг бол хамтын санд олон нийтэд хөрөнгө оруулах эрх нь нээлттэй зэрэгцээ илүү өндөр зохицуулалттай байдаг.

Зураг. Хөрөнгө оруулалтын сангийн төрөл



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль

2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дотоодын зах зээлд нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаа, оролцоог дэмжсэн “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”, “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-уудыг шинэчлэн баталлаа.

Зураг. Хөрөнгө оруулалтын сангийн төрөл

Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам

Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам


Эдгээр журмыг баталснаар хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулахад тавигдах нөхцөл, шаардлага илүү хялбар болохоос гадна хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, нэгж эрхийн танилцуулгыг олон нийтэд танилцуулах, сангийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны зохион байгуулалт, үйл ажиллагаа, активт тавих шаардлага, мэдээллийн ил тод байдалтай холбоотой зохицуулалт сайжирна. Тухайлбал, “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-аар хамтын нээлттэй болон хаалттай хөрөнгө оруулалтын сангийн онцлогоос хамааруулж үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг шинэчлэн тодорхойллоо.

Харин “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар тусгай зөвшөөрөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, нөхцөл, ёс зүйн зарчим, мэдээллийн ил тод байдал, үүрэг, хариуцлагыг сайжруулахын зэрэгцээ дотооддоо сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлсэн тогтолцоо, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх болон дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй байх зэрэг зохицуулалтыг бүрдүүлээ.

Журмуудын зохицуулалт хэрэгжиж эхэлснээр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын сангууд нэмэгдэж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь бэхжихээс гадна шинэ бүтээгдэхүүний тоо өсөж улмаар үнэт цаасны арилжаа, хөрвөх чадвар, зах зээлийн үнэлгээ нэмэгдэх юм. Цаашилбал гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх оролцоо, зах зээлд итгэх итгэл өссөнөөр хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой.

Хамтын хөрөнгө оруулалтын санг (ХОС) хөрөнгө оруулалтын менежментийн компани удирддаг. Өөрөөр хэлбэл, таны хөрөнгийг мэргэжлийн хөрөнгө оруулалтын менежер удирдана гэсэн үг юм. Та хөрөнгө оруулагч болох хүсэлтэй ч шаардлагатай судалгаа, шинжилгээг хангалттай түвшинд хийхгүй л бол оновчгүй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулснаар өөрийн хөрөнгөө алдах эрсдэлтэй тул сангийн нэгж эрхийг худалдан авч, өөрийгөө эрсдэлээс хамгаалах боломжтой.

Зураг. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа



Эх сурвалж: Судлаачийн зураглал

Зураг. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ХОМК, ХОС, 2022 оны 2 дугаар улирал



3 арилжааны банк



35 хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компани



33 ХОС

29 хувийн ХОС

4 хамтын хаалттай ХОС

Мөн сангийн хөрөнгийг нэгж эрх эзэмшигчдийн нэрийн өмнөөс хадгалах чиг үүргийг кастодиан хэрэгжүүлдэг бөгөөд тухайн сангийн хөрөнгийг бодлогын баримт бичигт заасны дагуу удирдаж байгаа эсэхэд хяналт тавьдаг. Хэрэв хөрөнгө оруулалтын бодлогоос зөрсөн санхүүгийн хэрэгсэлд сангийн хөрөнгийг байршуулах шийдвэр гарсан тохиолдолд кастодиан нь нэн даруй сангийн удирдлага болон хяналт тавьж буй байгууллагуудад мэдэгдэж холбогдох арга хэмжээг авах үүргийг хүлээдэг.

### Хөрөнгө оруулалтын сан

### Хувьцаа

Тодорхойлолт	Хөрөнгө оруулагчдаас мөнгө цуглуулж, мэргэжлийн хөрөнгө оруулалтын багаар дамжуулан төрөл бүрийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг. Сангаас олсон ашгийг хөрөнгө оруулагчдын дунд хуваарилан тараадаг.	Хувьцаа нь компаниудын гаргасан санхүүгийн хэрэгсэл юм. Хувьцааны хөрөнгө оруулалт нь танд компанийн тодорхой хэсгийг өмчлөх боломжийг олгоно.
Мэргэжлийн удирдлага	Хөрөнгө оруулалтын сан нь мэргэжлийн багаар удирдуулдаг. Сангийн менежер болон зөвлөхүүд нь хөрөнгийн зах зээлийн тодорхой судалгааны үндсэн дээр хөрөнгө оруулалтын бодлогын дагуу хөрөнгө оруулалтуудыг хийн хөрөнгө оруулагчдадаа өгөөжийг хуваарилдаг.	Хувьцаа нь ганцаарчилсан хөрөнгө оруулалт тул таны мөнгийг удирдах мэргэжлийн хүн гэж байхгүй. Та аль компанийн ямар хувьцааг авахаа өөрөө шийдэх тул хөрөнгө оруулалтын өгөөж зөвхөн танаас хамаарна.
Эрсдэлийн төрөлжүүлэлт	Санд хөрөнгө оруулснаар таны мөнгийг олон төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тархаан байршуулж эрсдэлийг бууруулах боломжийг бий болгодог.	Хувьцаагаар дан ганц хөрөнгийн зах зээлд ордог тул бусад хөрөнгө оруулалтын зах зээлд орж төрөлжүүлэлт хийх боломжгүй.

### Хөрөнгө оруулалтын сангийн давуу талууд

- ◆ Өндөр өгөөж – Таны оруулсан хөрөнгийг сан нь гаднын болон дотоодын өндөр өгөөжтэй хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийдэг.
- ◆ Бага татвар – Хөрөнгө оруулалтын сангаас хуваарилах орлогоос та татварын давуу тал эдлэх бүрэн боломжтой.
- ◆ Мэргэжлийн баг – Таны оруулсан хөрөнгийг мэдлэг туршлага бүхий мэргэжлийн хөрөнгө оруулагчид удирдах тул та заавал хөрөнгө оруулалтын талаар мэдлэг, чадвартай байх албагүй.
- ◆ Хугацаа – Сан нь нарийн судалгаан дээр үндэслэн, оновчтой хөрөнгө оруулалтын аргыг ашиглан хөрөнгийг тань удирдах тул таны цагийг хэмнэнэ.
- ◆ Хөрвөх чадвар – Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг та хүссэн үедээ сандаа эргүүлэх, худалдах боломжтой тул хөрвөх чадвар сайтай хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тооцогддог.
- ◆ Тогтмол хөрөнгө оруулах боломж – Сан нь эрэлтийн хэмжээгээр нэгж эрх нэмж гаргадаг тул та сар бүр өөрийн орлогоос тогтмол дүнгээр хөрөнгө оруулалт хийж хөрөнгөө хуримтлуулахад нээлттэй.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Цаашид хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзлэх хувь нэмэгдэх хандлагатай тул зохицуулагч байгууллагын зүгээс тус салбарыг өндөр хөгжилтэй улс орны жишигт нийцүүлэн хөгжүүлэхэд уян хатан зохицуулалтыг бий болгох, татварын таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын бодлогоор дамжуулан тогтвортой байдлыг хангаж гадаад, дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай. Түүнчлэн мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хөрөнгө зарцуулалтын ил тод байдлыг сайжруулах, мэдээллийн тэгш бус байдал зэрэг микро, макро эдийн засгийн саад бэрхшээлийг арилгахад анхаарч ажиллах хэрэгтэй. Татварын таагүй орчноос шалтгаалан хөрөнгө оруулалт менежментийн компани, хөрөнгө оруулалтын сангуудын оролцоо, бүтээгдэхүүний нэр төрөл цөөн байгаа учир хөрөнгө оруулалтын сангийн орлогыг татвараас чөлөөлөх зэрэг татварын бодлогоор дэмжин ажилласнаар мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэнэ.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын зүгээс хөрөнгө оруулалтын бодлогоо тодорхойлохдоо Тогтвортой хөгжлийн зорилтууд болон байгаль орчин, нийгэм, засаглалын стандартад нийцүүлэх, хүний нөөцийг мэргэжлийн өндөр түвшинд байлгах шаардлагатай тул салбарын хүний нөөцийн хөгжилд анхаарч ажиллах шаардлагатай.

Иргэд хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, санхүүгийн боловсрол дутмаг байгаатай холбоотой эрсдэлтэй алхам хийх нь элбэг байдаг тул иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь зүйтэй.

## ТАВ. ЭХ СУРВАЛЖ

- ◆ “Алсын хараа 2050” – Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Амьдралын чанар ба дундаж давхарга
- ◆ Олон улсын санхүүгийн корпораци, Их 20–ийн хөрөнгө оруулагчдын чуулганы тайлан, 2020
- ◆ Institutional investor
- ◆ <https://www.institutionalinvestor.com/article/b1lpqhcvgfils0h/Changing-the-Investor-Experience>
- ◆ Хөгжиж буй улс орнуудын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх нь судалгаа, Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, 2021
- ◆ Local investor base diagnostic, KPMG, 2022
- ◆ <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD384.pdf>

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС


### ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Компанийн засаглалын орчин үеийн чиг хандлага байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа бөгөөд улс орнууд даяарчлалын түвшинд нөлөөлөхүйц засаглалын шинэ дүрэм, журмыг нэвтрүүлэхийг зорьж байна.

Компанийн засаглалын орчин үеийн чиг хандлагыг манлайлахад дэм болох үүднээс Рассел Рейнольдс Ассошиэйтс (Менежментийн зөвлөх компани)–ээс жил бүр компанийн засаглалын хэтийн төлөвийг гаргадаг ба компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл

(ТУЗ) болон гүйцэтгэх удирдлагуудын өмнө 2023 он болон цаашид тулгарч болзошгүй компанийн засаглалтай холбогдох тулгамдсан асуудлыг тодорхойлох зорилгоор үндэстэн дамнасан мэргэжлийн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, тэтгэврийн сангийн менежерүүд, зохицуулагчид, итгэмжлэгдсэн зөвлөхүүд болон компанийн засаглалын мэргэжилтнүүдтэй ярилцлага зохион байгуулж, энэ удаагийн хэтийн төлөвийг боловсруулсан байна.

*Зураг. Компанийн засаглалын 2023 оны чиг хандлага*



#### 1. ТУЗ-ИЙН ЧАДВАР, ЧАДАВХ

Хувьцаа эзэмшигчид компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнд анхаарлаа хандуулах төлөвтэй байгаа тул энэ онд ТУЗ-ийн бүрэлдэхүүн, чадвар, гүйцэтгэлд онцгойлон анхаарч хяналт тавих хандлага түлхүү ажиглагдаж байна.

АНУ-ын хувьд компанийн гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага болон мэдээллийн ил тод байдалд илүү нухацтай хандахыг хувьцаа эзэмшигчид уриалж байна.

Харин Бразил Улсад хүйсийн тэгш, хараат бус байдал, нэр дэвшүүлэх үйл ажиллагааг нээлттэй явуулах, Энэтхэг улсын хувьд ТУЗ-ийн хараат бус гишүүдийн томилгооны шинэчлэлд анхаарч байгаа бол Европын Холбооны орнууд компанийн ТУЗ-ийн ур чадвар, бүтцийг сайжруулах хэрэгцээ шаардлагатай тулгарч байна.

Тухайлбал, ХБНГУ-д хөрөнгийн биржид бүртгэлтэй компани ТУЗ-дөө хоёроос доошгүй мэргэжлийн санхүүчтэй байхын зэрэгцээ тухайн компанийн тогтвортой байдлын талаар мэдлэг, ажлын туршлагатай байхаас эхлээд ур чадварын шаардлагууд бүх гишүүдэд тавигдаж байна.

Дээр дурдсанаар ТУЗ-ийн гүйцэтгэлийн үр дүн, бусад шаардлагыг ТУЗ-ийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх замаар хангаж болно.

## 2. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Дэлхийн хаана ч үйл ажиллагаа явуулж байгаагаас үл шалтгаалан эдийн засгийн хямрал, зах зээлийн эмх замбараагүй байдал компанийн засаглалын нөхцөл байдалд шууд нөлөөлж байна. Тухайлбал, Украин дахь цэргийн үйл ажиллагаа, “Ковид”-той холбоотой нийлүүлэлтийн дэд бүтцийн харилцан хамаарал бүхий хүндрэлүүд, инфляцын өсөлт зэрэг нь компанийн гүйцэтгэх удирдлагын манлайлалд дарамт учруулж буй бөгөөд олон улс оронд гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийн төлөвлөлт, хэрэгжилтэд нь хяналт тавих, залгамж халаа зэрэг асуудалд илүү анхаарал хандуулагдана гэж мэргэжилтнүүд үзжээ.

Хөрөнгө оруулагчид их хэмжээний нэмэгдэл зардал болон хэт их урамшууллаас бэрхшээж байгаа тул гүйцэтгэх удирдлагын нөхөн олговрын асуудалд анхаарч буй нь гайхах зүйл биш юм. Энэ чиглэлээр АНУ, Сингапур зэрэг улсын зохицуулалтын орчинд

ихээхэн өөрчлөлт, шинэчлэлүүд гарч байна. Их Британийн хувьд дээрх нөхцөл байдал нь байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын асуудалтай холбоотойгоор нөхөн олговор олгох хүлээлтэд хүргэж болзошгүй юм.

## 3. БОНЗ-ЫН ТӨЛӨВШИЛ БОЛОН ТАЙЛАГНАЛ

Зарим улс орнууд БОНЗ-ын хөтөлбөр хэрэгжүүлэхээс цааргалж байгаа хэдий ч хөрөнгө оруулагчид ихэнхдээ тогтвортой байдлын тайлагнал болон нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг сайжруулах шаардлагыг нэмэгдүүлсээр байна.

Хамгийн гол нь компанийн тогтвортой байдлын тайлангийн зөвлөмж нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартуудтай уялдан ирэх жилүүдэд БОНЗ-ын хэрэгжилтийн нөхцөл байдал, үнэлгээнд нөлөөлөх болно.

Дээр өгүүлснээр хувьцаа эзэмшигчид компанийн тогтвортой байдал, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх баталгааг шаардах хандлага өсөн нэмэгдэж байгаа тул БОНЗ-ийн хамаарах хүрээ тэр хэмжээгээр өргөжиж байна.


Уур амьсгалын өөрчлөлт нь Их Британийн хувьд анхаарал хандуулах дараагийн томоохон асуудал болж байгаа бөгөөд Энэтхэг улсын хувьд БОНЗ-ыг хэрэгжүүлэх ур чадварыг сайжруулах эрэлт хэрэгцээ нэмэгдсээр байна. Латин Америкийн улс орнууд мөн л уур амьсгалын хөтөлбөрт анхаарал хандуулах шаардлагатай тулгарч байгаа бол АНУ-д хүний нөөц, хөдөлмөрлөх эрхийн асуудал нэн тэргүүнд тавигдаж байна.

*Эх сурвалж: <https://corp.gov.law.harvard.edu/>*



## ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ГЭЖ ЮУ ВЭ?

“Даатгагчийн баталгаа” нь иргэн, аж ахуйн нэгж байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ даатгалын компанид шилжүүлж, даатгалын компани нь гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр төлөх баталгаа гаргахыг хэлнэ.



### Баталгааны төрөл



Тендерийн баталгаа



Урьдчилгаа төлбөрийн баталгаа



Гүйцэтгэлийн баталгаа



Ипотекийн зээлийн урьдчилгаа  
төлбөрийн баталгаа



Хуулиар хориглоогүй бусад  
баталгаа



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

## Цуврал №25

### Даатгагчийн баталгааны давуу тал



Иргэдийн ипотекийн зээлд хамрагдалтыг нэмэгдүүлэх;



ААН, ЖДҮ эрхлэгчид тендерт оролцохдоо даатгагчийн баталгааг ашиглах;



Иргэд, АНН-үүдийн санхүүгийн үйлчилгээний зардал буурч, үйлчилгээг илүү амар хялбар байдлаар авах;



Даатгалын салбарт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болсноор салбарын эрэлт, нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, санхүүгийн чадамжийг дээшлүүлэх;



Санхүүгийн салбар өргөжин тэлэх, мөнгөн урсгалын эргэлтийг нэмэгдүүлэх, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг дэмжих.



“ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ыг дараах QR кодыг уншуулан танилцана уу.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### 2023 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРД БНХАУ–ААС ХОЙД СОЛОНГОС РУУ ЭКСПОРТЛОХ ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ НЭМЭГДЖЭЭ.



БНАСАУ–д хийсэн экспорт энэ оны өнгөрөгч дөрөвдүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн ба онцлох бараа бүтэгдэхүүнүүд нь хиймэл үс, бордоо зэрэг байсан тухай, Хятадын гаалийн мэдээллүүд 2023 оны 5 дугаар сарын 21–ний бямба гарагт нийтэлсэн.

Хятадын Гаалийн ерөнхий газрын нийтэлсэн тоо баримтаас үзвэл, дөрөвдүгээр сард тус тусгаарлагдсан улс руу Хятадаас гадагшаа чиглэсэн бараа бүтэгдэхүүн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 69 хувиар өсч, 166 сая ам.долларт хүрсэн ажээ. Экспортын үнийн дүнд 11.6 сая ам.долларын үнэтэй хиймэл үс, ноос болон өргөн хэрэглэгддэг бордоо болох диаммонийн устөрөгчийн фосфат 8.84 сая ам.доллараар тус тус тэргүүлсэн байна.

Пхеньян энэ оны өнгөрөгч дөрөвдүгээр сард Хятадаас 5.07 сая ам.долларын будаа худалдаж авчээ.

Энэ оны нэгдүгээр сараас дөрөвдүгээр сард Хятадаас Хойд Солонгост хийсэн экспортын хэмжээ өмнөх оны 270.59 сая ам.долларын хэмжээнээс давж, 603 сая ам.долларт хүрсэн тухай гаалийн мэдээллээс харж болно.


Хойд Солонгос удаан хугацааны туршид хүнсний аюулгүй байдлын асуудалд нэрвэгдээд байгаа бөгөөд энэ оны хоёрдугаар сарын дундуур Өмнөд Солонгосын DongA Ilbo сонин Пхеньяны хүнсний хямрал даамжирсан байж болзошгүй гэж мэдээлсэн.

Тус улс 2006 оноос хойш пуужингийн болон цөмийн хөтөлбөр хэрэгжүүлснийхээ төлөө НҮБ–ын хоригт хамрагдаж байгаа юм.

*Эх сурвалж: Бээжин (Ройтерс)*

### ТОКИОГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГОЛ ИНДЕКС 32 ЖИЛИЙН ДЭЭД ҮЗҮҮЛЭЛТЭД ХҮРЧ ӨСЖЭЭ

Токиогийн хөрөнгийн биржийн 2023 оны 5 дугаар сарын 19–ний баасан гаргийн арилжаа өсөлттэй эхэлж, Японы тэргүүлэх 225 компанийн хувьцааны ханшийг харуулдаг “Nikkei” индекс сүүлийн 32 жилийн дээд үзүүлэлтийг шинэчилжээ. Уг индекс долоон өдөр дараалан өссөн байна.



Арилжаа нээгдсэнээс хойш эхний таван минутын дотор “Nikkei” индекс 1.05 хувиар өсөж, 30 900 нэгжид хүрсэн нь 1990 оны наймдугаар сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт болсон байна.

Японы үндэсний мөнгөн тэмдэгтийн ам.доллартой харьцах ханш суларсаар байгаа нь Токиогийн хөрөнгийн биржийн индексүүд өсөхөд нөлөөлж байгаа гол хүчин зүйл хэвээр байна. Иений ханш сулрах нь гадаад зах зээл рүү чиглэсэн, гадаад валютаар ашиг олдог Японы олон том корпорацуудад ашигтай юм. Түүнчлэн АНУ–ын Ардчилсан намынхан болон Бүгд найрамдах намынхан өрийн дээд хязгаарын талаар тохиролцоонд хүрч, дефолтоос зайлсхийж чадах төлөвтэй байгаа мэдээ хөрөнгө оруулагчдад мөн нөлөөлжээ.

Иений ханш 0.49 хувиар суларч, нэг ам.доллар 138.49–138.5 иентэй тэнцэж байна.

*Эх сурвалж: Токио. /NHK/*

### ХБНГУ–Д ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХҮНД НӨХЦӨЛД БАЙГАА ХЭДИЙ Ч ТОГТВОРТОЙ БАЙНА

Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа хэдий ч Герман дахь гадаадын хөрөнгө оруулалт 2023 онд тогтвортой хэвээр байна гэж



тус улсын эдийн засгийн хөгжлийн агентлаг болох Germany Trade & Invest (GTAI) 2023 оны 5 дугаар сарын 22—ны даваа гарагт танилцуулсан байна.

GTAI-ийн захирал Роберт Херманн Ройтерс агентлагт хэлэхдээ, “Украины дайн, эрчим хүчний хямрал, тахлын дараах сөрөг нөхцөл байдлыг харгалзан үзвэл энэ нь амжилт юм” гэж хэлжээ.

Германд хамгийн том хөрөнгө оруулагч нь 279 төсөл хэрэгжүүлсэн АНУ хэвээр байна. “Инфляцыг бууруулах тухай хууль (IRA)-ын дагуу АНУ-д дотоодын хөрөнгө оруулалтыг хүчтэй дэмжиж байгааг харгалзан үзвэл энэ нь гайхалтай үр дүн юм” гэж Херманн нэмж хэлэв.

Удаах байрт Швейцар 208 төсөл, гуравдугаарт Их Британи 170 төсөл хэрэгжүүлсэн бол “Тус хоёр улс хоёулаа ЕХ-ны гишүүн биш, гэхдээ тэд Германд дэмжлэг үзүүлэхийг хүсдэг бөгөөд ихэнхдээ л Германыг сонгодог” гэж Херманн хэлсэн.

Хятад улс 141 төсөл хэрэгжүүлснээр дөрөвдүгээр байрт орсон нь 2014 оноос хойших хамгийн бага үзүүлэлт болжээ. “Корона цар тахал мэдээж үүнд нөлөөлсөн” гэж Херманн хэлжээ. Турк улс 139 төсөл хэрэгжүүлснээр тавдугаар байрт дэвшсэн нь тус улсын дээд амжилт юм.

Зарлагдсан хөрөнгө оруулалтын хэмжээ 2022 онд 25 тэрбум евро (27.52 тэрбум ам.доллар) болж өссөн бөгөөд үүний дийлэнх хэсэг нь Америкийн хагас дамжуулагч үйлдвэрлэгч Intel (NASDAQ:INTC)-ийн амлалт бөгөөд энэ нь 17 тэрбум еврогийн анхны зардал бүхий асар том шинэ чип хийх цогцолбор байгуулахаар Германыг сонгосонтой холбоотой юм.

*Эх сурвалж: Берлин (Ройтерс)*

## МОНГОЛ УЛС, ФРАНЦ УЛСАД ЧУХАЛ МЕТАЛЛ НИЙЛҮҮЛЭХЭЭР ТОХИРОЛЦЛОО

Францад чухал метал нийлүүлэх талаар Парис Улаанбаатартай тохиролцлоо. Энэ тухай ням гарагт Францын Ерөнхийлөгч Эммануэл Макрон Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхтэй хийсэн хэлэлцээний дараа сэтгүүлчдэд мэдэгдэв.



“Бид эдийн засгаа нүүрснээс ангижруулах асуудлыг хөндсөн. Бид танай улсаас чухал метал нийлүүлэх замаар эрчим хүчний хараат бус байдлаа бэхжүүлэхийн тулд хамтран ажиллахаар шийдвэрлэлээ” гэж Э.Макрон мэдэгдээд чухам ямар металлын тухай яригдсаныг дурдсангүй.

Тэрбээр Монгол Улс Францын цөмийн технологийн “Огапо” корпорацитай хамтран ажиллах, тэр дундаа металлын олборлолтын салбарт хамтран ажиллах нь чухал болохыг онцлов. “Огапо” компанийн цахим хуудсанд мэдээлснээр, тус компани нь Монголд 25 гаруй жил гаруй үйл ажиллагаа явуулж, 2000-аад оноос хойш хайгуул хийж байгаа бөгөөд 2015 онд тус улсад ашигт малтмалын ашиглалтын лиценз авчээ.

Францын Ерөнхийлөгч ням гарагт Японд “Их долоогийн бүлэг”-ийн дээд хэмжээний уулзалтад оролцсоныхоо дараа Улаанбаатарт хүрэлцэн ирсэн юм. Энэ нь Францын төрийн тэргүүний Монгол Улсад хийж буй анхны айлчлал юм. Айлчлалынхаа хүрээнд Э.Макрон мөн тус улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэтэй уулзаж, Улаанбаатарт 2022 онд нээгдсэн Чингис хааны музейг үзэж сонирхов.


*Эх сурвалж: Улаанбаатар. /TASS/*

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр

S&P 500 /^GSPC/


**4,191.98** -6.07 (-0.14%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

Nikkei 225 /^N225/


**31,086.82** +278.47 (+0.90%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

FTSE 100 /^FTSE/


**7,780.66** +23.37 (+0.30%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

NASDAQ Composite (^IXIC)

**12,657.90** -30.90 (-0.24%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



[press@frc.mn](mailto:press@frc.mn)



[www.frc.mn](http://www.frc.mn)



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia